

Шинжээч

Амьдрал гэгч хөдөлгөөн, хөдөлгөөн гэдэг бол юмс үзэгдлийн нэмэгдэхүй, хасагдахуй хийгээд хуваагдахуй үржигдэхүй юм.

Дотоод гадаад олонлогийн тооны хувилбарыг шинжихгүйгээр бүхлийн болоод нэгжийн мандал бадрал, үхэл мөхлийг онон хэлэх буюу жолоодох аргагүй юм.

Тооны аажим өөрчлөлт чанарын хувиралт хүргэдэг жамтай.

Нийгмийн амьдралын чухам ийм далд талыг эдийн засагчид, статистикчид судалж олон хамаарлаас дүгнэлтээ гаргаж тэр нь удирдлагын жолоо цулбуур болдог.

Монгол улсын нэг аймаг гэдэг бол учир шалтгааны үй түмэн хэлхээ холбоонд шүтэлцэн барилдсан амьдрал хөгжлийн өөрийн онцлог хөдөлгөөн жамтай нийгмийн нэгэн бүхэл юм.

Би ийм бүхлийн ерөнхий шинжээчээр 25 жил ажилласан Лутын Нацагдоржийн мэргэжлийн онцлогыг нээн харуулах гэж үүнийг дурьдаж байгаа хэрэг. Тоон утгын мөн чанарт хатуу нэг л хариу гардаг шиг ажилдаа яс, үг яриа ч түс тас, зан ааш нь гүдэс шудрага, хөндлөнгөөс нь ажиглахад хянамгай чанга Нацагдоржоос Төв аймгийнхан хорь гаран жил лавлаж шалгааж гүйлдсний учир бол мэргэжлийнх нь өндөр чадварт татагдсаных юм.

-Хамгийн үнэн гэж статистикийн тоо нэхнэ. Амралтын өдөр дэлгүүрт ч, ажлаадаа гудамжинд явахад ч хүмүүс тоо нэхдэг учир аймгийн үйлдвэрлэлийн өчигдөр өнөөдрийн дүн мэдээ цээжинд бэлэн явна. үүр шөнөөр ч олонтоо мэдээ судалгаа танилцуулах хэрэг гарах тул хэлтсийнхээ 10 хүний сейфний түлхүүрийг өвөртлөж харина.

Дуудахад нэхсэн тоог нь дор нь олоод өгчихнө. Нойр хагас ажилтнуудаа жавар шуурганд тух алдуулахгүйсэн гэхдээ л тэр. Бидний хэн маань ч гэртээ ховор байж дээ.

Түүний энэ ярианаас ажлынх нь дүр эрх биш харагдана байгаа.

-Аймгийнхаа эдийн засаг, тоо бүртгэлийг авч явах сургууль хийсэн анхны мэргэжилтэн та нар боллоо. Эндээс гэрлэж суурьшилтай ажиллаарай гэж аймгийн дарга догдлонгуй хэлж цэцэг гардуулсан нь 1964 он.

Төв аймгийн үйлдвэрлэл эдийн засгийн амьдралыг тоогоор магадлаж шинжлэх Нацагдоржийн ажлын гараа ердөө л ингээд эхлэхив.

Амьдрал үйлдвэрлэлийн нэгжээс тоогоо цуглуулж ахмад багш Хаянхярваагаасаа ажлын арга дүй сурч, аймгийн амьд хөдөлгөөний тоон зураглал толгойд нь тогтож явтал сургууль төгсөхдөө тохиолдлоор анх өвөртлөж ирсэн албан тамга 1972 онд гарт нь шилжжээ.

-Шудрага айхтар явлаа. Би тамгаа өвөртлөж яваад мэдээ худал гаргасан, хугацаа хоцроосон сумдынхныг торгож хариуцлагажуулна. Ер нь тэр үеийн миний гол албат сумын орлогч дарга нар их дуулгавартай.

Хэзээ ч дуудахад бэлэн ирнэ. Ирэхгүй бол машин явуулж авахуулаад зардлыг нь төлүүлчихнэ. Манай гаргадаг бүх мэдээ судалгаа чинь сайд нарын зөвлөл баталчихсан графикт хугацаатай. тэгэхээр хугацаа, үнэн хоёр л тун чухал. Статистикийн хэлтсээс гарч байгаа бүхий л мэдээ судалгаа дүгнэлтийн үнэн мөнийг би хариуцана.

Ажилтнуудынхаа хэнийх нь ч хийснийг би чухам л шалгах шиг болно. Миний гарын үсэггүй ганц ч тоо гадагш гарч байгаагүй.

Ажилдаа гүнзгий орж байж дээ гэж Нацагдорж ярьж байна.

Зуунмод хотод аймаг аймгийн машин давхилдаж танихгүй хүмүүс бужигнан хөл ихтэй.

-Нацагдоржийн хэлтсээс суралцмаар хэдэн чухал юм байна. Мэдээ судалгаа нь үнэн чанартай.

-аймгийн нийт ба цэвэр бүтээгдэхүүнийг жил бүр тооцож судалж дүгнэлт гаргадаг арга нь бидэнд бол цоо шинэ зүйл. 1978 оноос эхлээд он онд аймгийнх нь 12 салбарын үйлдвэрлэл, үйл ажиллагааны дүн 300 гаруй үзүүлэлтээр харагдаад толь л гэсэн үг юм

- Чухамдаа чухам. Эднийх чинь 3, 7, 10, 15 хоногт мэдээгээ шинэчлээд сум аймгийн удирдлагад, сониндоо мэдээлэл танилцуулга өгдөг юм байна шүү.

-Хаа-н техник ашиглалтын судалгааг сайхан хийжээ.

Эднийх чинь улсад үр тарианы үйлдвэрлэлтээ 1, төмсөөр 3-т, ХАА-н нийт бүтээгдэхүүний гаралтаар 3-т ордог аймаг. СМФ 16-тай гээд л бод.

-Танай Өвөрхангай л Нацагдоржийгоо авмаар юм.

-Манай Бүрдийнхэн ч санаа бий шүү. Эцэг нь Лут гэж багийн дарга явсан малчин хүн, өвөг эцэг нь Ширчингийн Мөнх гэж Зоригт вангийн хошуу тамганд бичээч түшмэл явсан юм гэнэлээ. Төр түшицгээж л явсан удамтай эр дээ.

Ийм яриа аймгийн гүйцэтгэх захиргааны гадаа үзүүлэх сургуулиас завсарлагсдын дунд болж билээ.

Нацагдорж даргын өнгөн дээр аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны статистикийн хэлтэс ажлаараа шалгарч БНМАУ-ын Статистикийн Төв газарт 6 жил эхний байруудад шалгарчээ. Ингээд бүх аймгуудын статистикийн ажилтнуудын үзүүлэх сургууль Төв аймагт 4 удаа хийгдэв.

Нацагдорж ч Алма-Ата, Москвад мэргэжил дээшлүүлж арга чадвар нь улам ч чамбайраад ажлын багаж сампин нь электрон машинаар олшруулагч бал харандаа хорын цаас нь хувилагч техникээр солигдож ирлээ.

Өөрийг нь ч бүртгэл статистикийн тэргүүний ажилтан хэмээн үнэлээд засгийн газрын жуух бичиг, хөдөлмөрийн хүндэт медалиар шагнасан байна. Ийнхүү мэргэшсэн боловсон хүчнийг мэргэжлээс нь яагаад хөндийрүүлсэн юм бол гэж танд бодогдохгүй байна уу.

Чуулганы танхим өнгө өнгийн гэрлээр цахим хөгжим эгшиглэн гайхамшгийн сүрээр чимсэн сүлд мод тойрон хүмүүс бүжиглэнэ.

Өвлийн өвгөн билэгт үгээ хэлж дөнгөж дуусуут Нацагдорж хэлтсийнхээ хэдийг дагуулан гарав. Хэнхэг хэнхэг гэхэд шинэ жилийн ганц үдшийг тэсэж болдог байгаа даа гэж би бодож суулаа.

-Баяр ёслол ёлка болж л байна. Бид бахь байдгаараа өрөөндөө тоо, сампинтайгаа . . . жилийн эцсийн дүн мэдээ, мал тооллогын дүн нэгтгэх, аймгийн намын хорооны бүгд хурал, АДХ-ын чуулганы илтгэлийн дүгнэлт гаргах гээд суухаас өөр аргагүй.

Сар улирал жилийн эцэст, хурал зөвлөлгөөний өмнө нойргүй хононо.

Эхнэр хүүхэд маань ч үүнд дасчихсан. Бидний ажлын онцлогыг дарга нар ойлгоно. Аймгийн намын хорооны 1 нарийн бичгийн дарга Б.Дэжид гуай Та нар дуртай цагтаа орж

ирж ажил танилцуулж байгаарай гэж тэр л жишгээрээ удаа дараагийн дарга нар хандаж ирсэн юм гэж Нацагдорж ярьж сууна.

Аргагүй шүү дээ. Амьдрал үйлдвэрлэлийн бүх хөдөлгөөний жинхэнэ үнэн үйл оношийн тоог барьж байгаа эмч шинжээчдээ гэхгүй бол хэнийг гэх вэ.

Нацагдорж аймгийн депутатаар 4 удаа сонгогдсон нь ч тийм учиртай биз. Нийгмийн хөдөлгөөн ончрох зангирах гэж байдаг.

1988 онд статистикийн хэлтсүүдийг татан буулгасан нь чухам тийм шалтгаантай биз гэж бодогдоно. Монголын нийгмийн үйлдвэрлэлийн доройтлын тоон утга илэрхий болоход бухимдсан дарга нар толио хаг цохисон нь тэр биз.

Эдийн засаг эрүүлжээгүй болохоор одоогийн шинэ төр засаг ч статистикийнхэнд нэг их ач холбогдол өгсөн юм уу даа. Тэгээд ч манай Нацагдорж шиг шулуун шудрага хүн амьдралыг нарийн судалчихна, үнэнийг хэн гуайд ч айхгүй хэлчихнэ. Түүнийг Нефть баазын даргаар томилжээ. Томилсон л бол хийх ёстой гэсэн үзэл маний үеийнхэнд байлаа.

Дараа нь Нацагдорж Зуунмод хотын татварын тасгийн анхны даргаар томилогдоод ажиллав. Юунд ч тохоосон тэр хийж чадна л даа. Одоо аймгийн татварын хэлтсийн орлого татвар хариуцсан улсын байцаагчаар ажиллаж явна. Яахав. Хүн ямар ч ажлыг гарын ая даалгаж явах шиг сайхан юм хаа байх вэ.

(Ш.Цэрэндоогийн "Амьдрал шинжсэн тоочид" номоос)